



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/159

Хэрлэн сум

Зудын гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Улсын онцгой комиссын даргын 2023 оны 8 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутгийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг хангуулах үйл ажиллагаанд шаардагдах 3,726,100 (гурван сая долоон зуун хорин зургаан мянга нэг зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.


3.Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д, шуурхай штабын үйл ажиллагааг сайжруулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д даалгасугай.

4.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
08 дугаар сарын 29-ны
дугаар захирамжийн хавсралт

ШААРДАГДАХ ТООЦОО

д/д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Мөнгөн дүн
1	Хоолны зардал	140	3.276.100
2	360 градус камер DTZ	1	450.000
	Нийт		3.726.100